



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 58

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон нийт 4 нэрийн 30,024,429,418.00 (гучин тэрбум хорин дөрвөн сая дөрвөн зуун хорин есөн мянга дөрвөн зуун арван найман) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Гаалийн ерөнхий газрын харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



13201108

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2021 оны 03 дугаар сарын 09-ний
өдрийн 58 дугаар тогтоолын хавсралт

**Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон
Гаалийн ерөнхий газрын харьяа байгууллагын үндсэн
хөрөнгөд бүртгэх хөрөнгийн жагсаалт**

Д/д	Хөрөнгийн нэр, марк дугаар	Ашигла лтад орсон он	хүчин чадал		Нийт үнэ (төгрөгөөр)	Хүлээн авч ашиглах, бүртгэх байгууллагын нэр
			хэм жих нэгж	биет хэм жээ		
1	Шуурхай удирдлагын төв барилга	2020	м2	8931	14,755,479,878.00	Гаалийн ерөнхий газрын
2	Гаалийн төв лаборатори	2020	м2	6666	13,393,053,091.00	Үйлчилгээ, аж ахуйн газар
3	Баянхошуу боомтын салбар лабораторийн барилга	2020	м2	252	758,027,449.00	Дорнод аймаг дахь гаалийн газар
4	Өмнөговь аймаг, Оюутолгой дахь Гаалийн хяналтын бүсийн салбар лабораторийн барилга	2020	м2	504	1,117,869,000.00	Гашуунсухайт дахь гаалийн газар
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН				30,024,429,418.00 (гучин тэрбум хорин дөрвөн сая дөрвөн зуун хорин есөн мянга дөрвөн зуун арван найман)	